

Уур амьсгалын шударга ёсны төлөөх феминист үйлсийг шат ахиулав

Оршил

Жендэр ба ногоон үйлсийн төлөө олон улсын эвсэл¹ (GAGGA) нь дэлхийн өмнөд бүсийн улс орны хүн төвтэй уур амьсгалын шударга ёсны болон эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөнүүдийн хамтын шаардлагын хариуд засгийн газрууд, хөрөнгө оруулагчид болон донорууд зохих арга хэмжээ авахыг баталгаажуулах зорилготой. Газар булаах, ой мод устгах үйлдэл, байгалийн баялагийн олборлолтын эсрэг ялангуяа эмэгтэйчүүд² уйгагүй тэмцэл өрнүүлээд зогсохгүй хүн төрөлхтөн, дэлхий ертөнцийг хайрлан хамгаалахын төлөөх жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлүүдийг бататган шат ахиулсаар ирсэн билээ.



Гэрэл зураг: Ben den Engelsen

2021 он бол шийдвэр гаргагчдын хувьд уур амьсгалын гамшиг, сүйрлээс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаагаа сайжруулж, яаралтай арга хэмжээ авахад шийдвэрлэх мөч байв. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерресийн хэлснээр, уур амьсгалыг судлаачдын дүрсэлсэн дүр зургийг 'хүн төрөлхтөнд анхааруулж буй улаан гэрэл' гэж ойлгох нь зүйтэй. Азаар, уур амьсгалын шударга ёсны хөдөлгөөний шаардлагууд нь уур амьсгалын тухай хэлэлцүүлэг, хэлэлцээрийн анхаарлын төвд ордог боллоо. Феминист бөгөөд асуудлуудын огтлолцлын алсын хараагаар байгаль орчин, уур амьсгалын хямралыг хөнддөг орон зай нь 2021 онд ялангуяа олон улсын хэмжээнд хүрээгээ тэлэв. Уур амьсгалын хямралын давхар нуанс, үүний капитализм, эцгийн эрхт ёс, колонилол, арьсны өнгөөр ялгаварлах үзэл зэрэг дарангуйлал, ноёрхолын түүхэн тогтолцоотой уялдах холбоог засгийн газрын төлөөллүүд, засгийн газар хоорондын байгууллагууд болон санхүүжүүлэгчид ухамсарладаг болов. Жишээ нь, НҮБ-ын Үе хоорондын тэгш байдлын форумар Үйл ажиллагааны 6 эвслийн нэг нь уур амьсгалын шударга ёсны төлөө феминист үйлсийг онцолсон. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Талуудын 26-р бага хурлаар (ТБХ) өмнөх 25-р хурлын үеэр санал нэгдсэн Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх тохироо бүрдсэн. Түүнчлэн 2022 онд хуралдсан НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын тухай комисс нь жендэрийн эрх тэгш байдалд хүрэх асуудлыг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны болон гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийн хүрээнд уялдуулан авч хэлэлцжээ.

2021 онд бид шаргуу зүтгэсний эцэст хэдэн чухал ялалт байгуулав. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл эрүүл, даацтай орчны хүртээмжийг түгээмэл эрх хэмээн хүлээн зөвшөөрсөн тогтоол баталсан нь байгаль орчин, уур амьсгалын хямралыг хүний эрхэд суурилсан арга барилаар шийдвэрлэх ажлыг бэхжүүлсэн. ТБХ-ын 26-р хурлаар Засгийн газрууд 2030 он гэхэд нүүрсний хэрэглээг 'үе шаттай бууруулж,' метаны ялгаруулалтыг багасгаж, ой устгахыг арилгана гэсэн амлалт авсан. Төрийн ба хувийн хэвшлийнхэн сүүлийн үед шатах ашигт малтмалаас татгалзах чармайлт гаргаж байгаа бөгөөд Нидерландын шүүх "Шелл" компанид нүүрстөрөгчийн ялгаруулалтаа бууруулахыг үүрэг болгосон нь дэлхийн дулаарлыг 2°C-с доош хязгаарлаж, 1.5°C-д барихыг зорилт болгож 2015 онд дэлхий нийтээр санал нэгдсэн Парисын хэлэлцээрт заасан бодлогод нийцүүлэн компаниудад хууль эрхзүйн хариуцлага хүлээлгэж буй анхны тохиолдол юм.

¹ 2016 онд үүсгэн байгуулагдсан GAGGA нь Mama Cash, Both ENDS байгууллагуудтай хамтын ажиллагаа бүхий Төв Америкийн Эмэгтэйчүүдийн Сангаар (FCAM) удирдуулсан, консорциум юм. GAGGA нь дэлхий даяар өрнөж буй эмэгтэйчүүдийн эрхийн болон жендэр, уур амьсгалын бөгөөд байгаль орчны шударга ёсны төлөөх хөдөлгөөнүүдийн хамтын хүчийг зангиддаг.


² Байгаль орчныг хамгаалагч охид, эмэгтэйчүүд гэдэгт GAGGA охид, эмэгтэйчүүд, интерсекс, транс болон хүйсийн аль нэг туйлд харьяалагддаггүй хувь хүмүүсийг багтааж ойлгодог.

Хүнд сорилууд хэвээр үлдэв

Хийх ажлууд их үлдлээ. Уур амьсгалын хямралын суурь шалтгааныг хөндөх тал дээр дэлхийн хэмжээнд хангалттай ажил хийгдэхгүй байна. Нүүрстөрөгчийн ялгаруулалт дэлхийд 2021 онд түүхэндээ хамгийн өндөр байв. Засгийн газрууд уур амьсгалын санхүүжилт зэрэг чиглэлээр Парист хүлээсэн амлалтаа биелүүлээгүй байгаа. Шатах ашигт малтмалын үйлдвэрүүд төрөөс их хэмжээний татаас авсаар байгаа бөгөөд олон улсын санхүүгийн байгууллага зэрэг хувийн хэвшлийнхэн уур амьсгалын хуурамч шийдлүүдийг сурталчлан дэмжсээр байна. ТБХ-ын 26-р хурал нь КОВИД-19-ын цар тахлын хөл хорио, вакцины хүртээмжгүй байдал, боломжийн үнэ бүхий байр, буудлын хомсдол болон дэлхийн өмнөд бүсийн улс орны оролцогчдын оролцоог хязгаарласан бусад саад тотгорын улмаас оролцоог хангаагүй арга хэмжээ болсон.

Үүний хажуугаар, үндэсний ба орон нутгийн түвшинд иргэний нийгмийн байгууллага, нийгмийн хөдөлгөөн болон олон нийт нь ядуурал, арьсны өнгөний ба жендэрийн тэгш бус байдал, улс төрийн тогтворгүй байдал, уур амьсгалтай холбоотой гамшиг зэрэг цар тахлын уршгаар улам доройтсон олон янзын, хоорондоо уялдаатай нийгэм, эдийн засаг, байгаль орчны дарамттай нүүр тулгарсан. Дэлхийн өнцөг булан бүрийн байгаль орчныг хамгаалагч охид, эмэгтэйчүүд төрийн дэмжлэгтэй хүчирхийлэл, корпорациудын олборлолт зэрэг бүтцийн хүчирхийллийг биеэр туулсаар байна. Иймд GAGGA-гийн ажил урьд өмнөхөөсөө илүү чухал болж байна.

GAGGA 2021 онд: Онцлох тоо баримт



Онцлох тоо баримт

2021 он бол GAGGA-гийн 'Эмэгтэйчүүд уур амьсгалын үйл ажиллагааг манлайлах нь' шинэ хөтөлбөрийн эхний жил бөгөөд энэ нь 2016 оноос хойш бидний хийсэн ажлын үр дүн, бат бөх сүлжээн дээр суурилсан. GAGGA нь сүлжээний түншүүдэд 4.4 сая Еврогийн тэтгэлэг олгов. GAGGA-гийн түншид хувьсган өөрчлөх чадвартай жэндэрийн хувьд шударга уур амьсгалын үйл ажиллагааг манлайлдаг эмэгтэй удирдагчтай олон нийтэд түшиглэсэн байгууллагууд (ОНТБ), эмэгтэйчүүдийн болон байгаль орчны шударга ёсны сангууд болон ТББ-ууд багтдаг. 2021 онд GAGGA нь дараах байгууллагуудыг дэмжиж ажилласан:

2021 онд GAGGA-гийн дэмжлэг хүртсэн байгууллагуудын тоо, төрөл:



358 ОНТБ | **28** ТББ | **24** сан

GAGGA
өгсөн



€4.4 сая Евро

Сүлжээний
түншүүдэд олгосон
тэтгэлэг



ОНТБ-ууд,
бүсээр





Сан & ТББ-ууд,
бүсээр



ОНТБ-ын олон
нийтийн гол төлөөлөл,
айдентити



2021 оны төсвийн
хуваарилалт
Сан & ТББ-ууд



2021 оны Онцлох үйл явдлууд



Марсиа Мура [зүүн талд байгаа зураг] нь нийгмийн болон байгаль орчны эрхийн төлөө тэмцэж буй бүс нутгийн болон үндэсний уугуул иргэдийн хөдөлгөөнд оролцдог Бразил дахь Мура уугуул иргэдийн нэгдлийн нэг хэсэг юм.

1. Жендэрийн хувьд шударга уур амьсгалын үйл ажиллагаа, шийдлүүдийг сайжруулахын тулд орон нутгийн эмэгтэйчүүдийн манлайлал, тэсвэртэй байдал, чадавхийг бэхжүүлэв

GAGGA нь олон нийтэд түшиглэсэн байгууллагуудын (ОНТБ) жендэрийн хувьд шударга уур амьсгалын үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр санхүүгийн ба санхүүгийн бус төрөл бүрийн дэмжлэг үзүүлжээ. **Азид уул уурхайн эсрэг тэмцэж буй эмэгтэйчүүд (WAMA)** байгууллага нь GAGGA-гийн дэмжлэгтэйгээр Индонез, Баруун Папуа, Монгол, Филиппин, Энэтхэг болон Камбож улсын эмэгтэйчүүдтэй ур чадвараа хуваалцах ажлыг зохион байгуулсан. Олборлох үйлдвэрлэлийн усанд үзүүлж буй нөлөөлөлд төвлөрсөн тухайн арга хэмжээг КОВИД-19-ын улмаас цахим хэлбэрт шилжүүлж, гурван арга хэмжээ зохион байгуулжээ. Тус цахим арга хэмжээгээр эмэгтэйчүүдийн орон нутгийн мэдлэг, туршлага болон ус хамгаалах уламжлалт аргуудыг ашиглаж, усны эх үүсвэрт үзүүлэх уул уурхайн ажиллагааны нөлөөллийг судлах сургалт хийж, ус ба эмэгтэйчүүдийн харилцааны тухай болон усны аюул нь эмэгтэйчүүдийн эрхэд хэрхэн заналхийлж буй талаарх ойлголтыг тус тус бэхжүүлжээ.

Уганда улсад **Эрчим хүчний засаглалын Африкын хүрээлэн (AFIEGO)** байгууллага нь шугам сүлжээнээс гадуур нарны эрчим хүч, хүртээмжийн ашиг тусын талаар мэдлэг бүхий нутгийн эмэгтэйчүүд, залуус, ахмадуудыг эрхмэдэлжүүлэх чиглэлээр 2021 онд орон нутгийн олон нийтийн оролцоог хангасан хэд хэдэн ажлыг зохион байгуулжээ. Ирээдүйн нөлөөллийн ажлыг дэмжих үүднээс эмэгтэйчүүдийн болон залуучуудын нарны клубыг үүсгэн байгуулсан байна. Эдгээр клубээр дамжуулан эмэгтэйчүүд, залуучууд орон нутгийн олон нийттэй хамтран ажиллаж, сүлжээнээс гадуур нарны эрчим хүч, сайжруулсан зуух болон гэрэлтүүлгийн талаар сурталчлан таниулжээ. Тус Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр цэвэр эрчим хүчний бодлого, тэр дундаа олон нийтийн түвшинд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхүйц бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажилд тэд бас оролцжээ. [Уганда улсын Статистикийн товчооны сүүлийн үед мэдээлснээр, нарны эрчим хүчний холболт 2017 онд 18% байсан бол 2020 онд 39% болж өсчээ.](#) Хүрээлэн өөрийн ажлын болон нарны клубын хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдтэй хамтран ажилласны үр дүнд энэхүү өсөн нэмэгдэж буй хандлагыг цаашид ч үргэлжлүүлнэ хэмээн найдаж байна.

Түүнчлэн 2021 онд GAGGA-гийн түнш сан, ТББ-ууд жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдэлд оролцох, манлайлах, баримтжуулах, сурталчлан таниулах чадавхиа дээшлүүлжээ. **Fondo Acción Solidaria, A.C. ба Fondo Semillas** байгууллагуудын удирдлага дор, мөн Both ENDS ба Төв Америкийн эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэйгээр Латин Америк дахь байгаль орчны шударга ёс, эмэгтэйчүүдийн сангууд жендэрийн болон уур амьсгалын шударга ёсны төлөө хамтын үйл ажиллагаагаа бэхжүүлэхийн тулд харилцаа холбоо, нөлөөллийн нэгдсэн стратеги боловсруулжээ. Энэ ажлыг феминист стратегийн харилцаа холбооны байгууллага болох La Sandía Digital чиглүүлсэн бөгөөд тэд жендэрийн болон уур амьсгалын шударга ёсны талаар үр дүнтэй харилцаа холбоог хөгжүүлэхэд оролцох хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэв.

Боливиин уугуул олон нийттэй ажилладаг **Colectivo CASA** нь Оруро дахь уурхайн нөлөөнд өртсөн байгаль орчныг хамгаалагч эмэгтэйчүүдэд байгаль орчны сургалт зохион байгуулжээ. Тэд борооны ус цуглуулах системд төвлөрсөн [‘Байгаль орчныг хамгаалагч эмэгтэйчүүд уур амьсгалын шударга ёсыг сурталчлан таниулах нь’](#) сэдэвт олон нийтийн аяны ажлыг хамтран боловсруулж хэрэгжүүлжээ. Цуглуулсан усаа хүнсний үйлдвэрлэлд ашиглах ба энэ нь олон

нийтийн хүнсний эрх, аюулгүй байдалд хувь нэмэр оруулна. Тухайн олон нийт усалгааны зориулалтаар PET хуванцар савыг дахин ашиглаж, усны савнууд дээр нийтэд зориулсан мессэж бичиж, орон нутгийн усны эх үүсвэрийг хамгаалахаар ойжуулалт хийж байна.

2. Уур амьсгалын, байгаль орчны болон эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөнүүдийг хооронд нь холбов

Сүлжээний түнш байгууллагууд өөр хоорондоо мэдлэгээ хуваалцаж, харилцан суралцахад тус дөхөмтэй учраас тэднийг холбох нь GAGGA-гийн ажлын чухал хэсэг юм. GAGGA-гийн шинэ хөтөлбөрийн эхний жилийг тохиолдуулан GAGGA-гийн эвслийн гишүүд түнш байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлж, шинэ хөтөлбөрийн тухай талуудын ойлголтыг лавшруулж, нийтлэг ашиг сонирхол, эрч хүч, нөөцийг тодорхойлон бэхжүүлэх зорилгоор 3 цахим сургалтыг зохион байгуулав. Эдгээр сургалтад GAGGA-гийн эвслийн гишүүд, стратегийн түншүүд, түншлэгч сан, ТББ, ОНТБ-уудын төлөөлөл зэрэг нийт 80 гаруй хүн оролцсон.

Жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлүүдийг шат ахиулахын тулд хөдөлгөөн хоорондын шинэ сэргэг түншлэлийг хөгжүүлж, өнөөгийн түншлэлийг улам бэхжүүлэх нь 2021 онд GAGGA-гийн түншүүдийн хувьд гол асуудал байв. Африкт гэхэд **WoMin** байгууллага нь ялангуяа уур амьсгалын шударга ёсны төлөө эмэгтэйчүүд нэгдэж, дуу хоолойгоо өргөхөд нь тэднийг зохион байгуулалтанд оруулж, хөдөлгөөн өрнүүлж, нэгдэхэд нь дэмжих зорилготой Африкийн Уур амьсгалын шударга ёсны төлөө нэгдлийг үргэлжлүүлэн тэлсээр байна. 5-р сард тус Нэгдэл Кот д'Ивуарт дэд бүсийн анхны уулзалт болох Франц хэлтнүүдийн Уур амьсгалын шударга ёсны тухай хурлыг зохион байгуулав. Хойд, Баруун, Төв Африкийн 14 улсын нийт 32 оролцогч оролцсон тус арга хэмжээ нь бүсийн хэмжээнд уур амьсгалын шударга ёсны хөдөлгөөнийг гүнзгийрүүлж, улмаар хэл, соёл, үндэс угсаа болон салбаруудын олон янзат байдлыг харилцан хүлээн зөвшөөрөхөд чухам алхам болсон.

1-р сард GAGGA-гийн стратегийн түншүүдийн нэг **350.org** нь 3 өдрийн арга хэмжээ болох [Шударга нөхөн сэргээлтийн төлөө дэлхийн хурлыг](#) зохион байгуулсан ба үүнд дэлхийн өнцөг булан бүрээс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг удирдагч, тэмцэгчид хэдэн мянгаараа хуран цугларчээ. Тус хурлын үеэр 196 салбар хуралдааныг 9 хэлээр орчуулж, 33 улсаас 80 гаруй илтгэгч, уран бүтээлчид оролцсон байна. Хурал нь эхнээсээ дуустлаа жендэрийн шударга ёсыг далайцтай онцолсон бөгөөд 14 салбар хуралдаан нь тодорхой феминист үзэл санаанд суурилсны дотор [Хүн, байгалийн төлөө эрх тэгш байдал, эв нэгдэл ба хамтын хайр халамж – Шударга нөхөн сэргээлтийн төлөө жендэрийн хувьд шударга, олон нийтэд түшиглэсэн тогтолцоо ба дадал практик, Жендэрийн болон уур амьсгалын хувьд илүү шударга дэлхий ертөнцийн төлөө хөдөлгөөн хоорондын хамтын ажиллагаа – GAGGA-гийн түршлага](#) гэсэн 2 хуралдааныг GAGGA гардан зохион байгуулсан.

3. Жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлийн төлөө засгийн газрууд, хөрөнгө оруулагчид болон доноруудад нөлөөлж ажиллав

2021 онд GAGGA-гийн гишүүд, түншүүд нь засгийн газар, хөрөнгө оруулагчид, доноруудад нөлөөлөх лобби, нөлөөллийн ажлын санаачлагуудыг манлайлж ажилласан. Филиппин дахь **LILAK** байгууллагын дэмжлэгтэйгээр уугууль иргэдийн төлөөлөл болсон эмэгтэйчүүд 2022 оны сонгуулийг угтан жендэрийн болон уур амьсгалын шударга ёсыг уриалах зэргээр мөрийн хөтөлбөрөө сурталчлан таниулахын тулд ажлын хэсэг байгуулжээ. Мөрийн хөтөлбөрт уугууль эмэгтэйчүүдийн дуу хоолойг тусгахын тулд тус ажлын хэсэг нь бусад хөдөлгөөнүүд, сүлжээтэй нэгдэж, кампанит ажилд оролцсон байна. Ингэснээр үндэсний 3 чухал хөтөлбөрт уугууль эмэгтэйчүүдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тусгасан бөгөөд эдгээр нь байгаль орчин, уур амьсгалын шударга ёсны төлөө тэмцэгчдийн томъёолсон Ногоон Хөтөлбөр; өргөн хүрээ бүхий үндэсний эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүдийн томъёолсон Эмэгтэйчүүдийн Хөтөлбөр; ба уугууль иргэдийн бүлгүүдийн үндэсний ба бүсийн түвшинд томъёолсон Уугууль Иргэдийн Хөтөлбөр байв. Эдгээр үндэсний хөтөлбөр нь 2022 оны сонгуулийг угтсан нөлөөллийн кампанит ажлын нэг хэсэг байсан юм.

2017 оноос хойш GAGGA-гийн Латин Америк дахь түншүүд Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөс (3-р сарын 8) Дэлхийн усны өдөр (3-р сарын 22) хүртэл **#WeWomenAreWater** буюу **#ЭмэгтэйчүүдБидБолУс** аяны ажлыг жил бүр зохион байгуулсаар иржээ. [2021 онд GAGGA болон түншүүд нь Ази, Африкын түншүүдийг эгнээндээ нэгтгэснээр аяныг дэлхийн түвшний ажил болгосон байна.](#) Үндсэн зорилго нь засгийн газрууд, хөрөнгө оруулагчид болон олон улсын хөгжлийн банкуудад тэдний шатах ашигт малтмалд оруулж буй хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа нь хэрхэн олон нийтийг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой усны хомсдол, бохирдолтой нүүр тулах ёстой болгодгийг, улмаар эмэгтэйчүүдийн үүрэг роль, манлайлал нь тэднийг ус хамгаалагч болгоход хүргэдгийг таниулах явдал юм. Аяны ажил нь эмэгтэйчүүдийн эрх ба устай холбоотой нөлөөллийн хүчтэй талбарыг бий болгохын төлөө GAGGA-гийн олон янзын түнш байгууллагуудыг нийтлэг уриан дор нэгтгэдэг билээ. Нийт 37 гаруй байгууллага Твиттер, Фейсбүүк болон Инстаграмаар дамжуулан аяны ажилд оролцож, Боливи, Гватемал, Гондурас, Энэтхэг, Индонез, Монгол, Нигери, Перу болон Өмнөд Африкийн түншүүдээс ирсэн 19 түүхийг нийтэд дэлгэжээ. Тус аяны ажлын ачаар GAGGA-гийн цахим хуудас 3,000 хандалт шинээр авсан байна. GAGGA-гийн Твиттер хуудас нь 48,700 сэтгэгдэл хүлээж авсан ба аяны ажлын үеэр тус хуудсаар хүмүүс 9,000-аас дээш удаа зочилжээ.

10-р сард GAGGA нэгэн чухал үр дүнд хүрсэн нь Нидерландын Үндэсний иргэний тэтгэврийн сан буюу ABP нь нүүрс, газрын тос болон хий үйлдвэрлэгчдэд оруулсан хөрөнгө оруулалтаа 2023 он гэхэд борлуулж дуусгана гэсэн хатуу бодлого гаргасантай холбоотой. Энэ шийдвэр нь Both ENDS байгууллагын Бразил, Нигери болон Уганда улсууд дахь түншүүдтэй хамтран олон жилийн турш кампанит ажил хийсний үр дүн бөгөөд тэд дээрх улс оронд оруулсан тус Сангийн хөрөнгө оруулалт, хүний эрхийн болон байгаль орчны зөрчлүүдийн хувьд хариуцлага хүлээх ёстой талаар зоригтой дуугарч, асуудалд шууд татан оролцуулж чаджээ. Нигери улсад гэхэд GAGGA-гийн түнш **Кебеткаче, Обеллегийн түгшсэн иргэд, Локиака** гэсэн байгууллагууд нь газрын тосны засаглал, хий шатаах байнгын үзэгдэл болон бохирдсон ус, тариалангийн газрыг Шелл компани цэвэрлэх шаардлагатай байгаа зэрэг асуудлын хүрээнд хэлэлцээр, шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг оролцуулж, бусад асуудлуудыг шийдвэрлэхэд ч дээрх Сан болон Нигери дэх Шелл компанийг шууд татан оролцуулжээ.

GAGGA нь Уур амьсгалын ногоон сангийн (УАНС) санхүүжилт жөндөрийн хувьд шударга байдлаар хуваарилагдаж, орон нутгийн эмэгтэй удирдагчтай ОНТБ-уудад хүрдэг байхыг хангахын тулд УАНС-д нөлөөлж ажилласаар байна. 2021 онд мэдээлэл солилцох, харилцан суралцах 3 албан бус сургалтыг үндэсний хэмжээнд УАНС, уур амьсгалын санхүүжилтын үйл явцад оролцдог GAGGA-гийн 12 түнш байгууллагатай хамтран зохион байгуулав. Харилцан суралцсанаар орон нутгийн болон үндэсний засгийн газартаа нөлөөлж ажилладаг ТББ-уудын чадавхи, мэдлэг болон эв санааны нэгдлийг дээшлүүллээ. Түүнчлэн Both ENDS нь УАНС-гийн Удирдах зөвлөлтэй шууд хамтран ажиллаж, цахимаар удирдах зөвлөлийн хуралд идэвхтэй оролцож, магадлан итгэмжлэл болон төслийн саналд үзэл бодлоо тусгасан. Both ENDS болон түншүүд болох Пуэрто Рико дахь **Олон улсын аналог ойн аж ахуйн сүлжээ (IAFN), CENDEP Камерун болон Proyecto Ayurveda** нь УАНС-гийн Нарийн бичгийн даргын газрын Экосистем ба хөдөө аж ахуйтай холбоотой Салбарын удирдамжид саналаа тусгасан байна. Агроэкологи нь өнөөдөр Салбарын удирдамжийн эх хувилбарт зорилтуудын нэгээр хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд үүнийг УАНС-гийн 2022 оны Удирдах зөвлөлийн хурлаар авч хэлэлцэх болно.

GAGGA чухал орон зайд шийдвэр гаргагч гол оролцогч талуудад нөлөөлөх үйл ажиллагааг манлайлах чиглэлээр стратегийн түншүүд болох Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сан, Проспера болон Байгаль орчин, хөгжлийн төлөөх эмэгтэйчүүдийн байгууллагатай (WEDO) хамтран ажилласан. ‘Тогтвортой шийдэл – Уур амьсгалын үйл ажиллагаанд жөндөрийн эрх тэгш байдлыг төвлөрүүлэх нь’ гэсэн 4 хэсгээс бүрдсэн цахим цуврал нь донор засгийн газрууд болон Европын хувийн сангуудын 30 гаруй төлөөлөгчдийг нэг дор цуглуулсан бөгөөд тэд эмэгтэйчүүдээр удирдуулсан уур амьсгалын үйл ажиллагааг дэмжиж, гэрээлэхийн ач холбогдол, энэ ажлыг аль хэдийнэ дэмжиж буй санхүүжүүлэгчдийн үр дүн ба сургамж болон гол боломжуудын талаар хэлэлцжээ. Үе хоорондын тэгш байдлын форумын үйл ажиллагааны 6 эвслийн нэг болох **Уур амьсгалын шударга ёсны төлөө феминист үйлсийн** хүрээнд GAGGA болон Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сан нь **амлалтын аяныг эхлүүлж**, ирэх 5 жилд уур амьсгалын шударга ёсны төлөө феминист үйлст нийт 100 сая ам доллар зарцуулахаар болов. Уур амьсгалын үйл ажиллагааны галын зурваст ажиллаж буй охид, эмэгтэйчүүд, транс, интерсекс болон хүйсийн аль нэг туйлд харъяалагддаггүй хүмүүс удирддаг байгууллагуудыг уян хатан байдлаар, олон жил дэмжих амлалтууд нь энэ аяны ажилд багтана. Нидерландын засгийн газар нь GAGGA-гийн ‘Эмэгтэйчүүд уур амьсгалын үйл ажиллагааг манлайлах нь’ хөтөлбөрт зориулж 37 сая Евро олгохоор болсон нь энэ аяны ажлын нэг хэсэг юм.

Талуудын 26-р бага хурлыг угтан GAGGA, Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сан болон WEDO нь тус хуралд оролцож, хэлэлцээр хийх засгийн газрын төлөөлөгчдөд зориулсан **‘Жөндөрийн хувьд шударга уур амьсгалын санхүүжилтын уриа’** гаргасан. Канад, Нидерланд, Швед болон Их Британийн нэгдсэн вант улсын засгийн газрын хамтран ажиллагсдаараа дамжуулан, мөн Тэгш Байдлын Сантай түншилснээр бид жөндөрийн хувьд шударга уур амьсгалын санхүүжилтын талаар засгийн газрын төлөөлөгчидтэй хоёр талт хэлэлцээр хийв. Ингэж хамтарч ажилласан нь эдгээр засгийн газартай болон бидний нөлөөллийн ажлыг дэмждэг гол оролцогч талуудтай харилцах манай харилцааг бэхжүүлсэн. Мөн Эмэгтэйчүүд ба жөндөрийн бүлгээр дамжуулан WEDO нь Талуудын 26-р бага хуралд оролцох феминист тэмцэгчдийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор нөлөөллийн ажлын сэдвээр цуврал цахим сургалтыг зохион байгуулсан.

Форд сангийн “Байгалийн баялаг ба тэсвэртэй эмэгтэйчүүд” санаачлагын хүрээнд GAGGA нь газар шороо, нутаг дэвсгэр ба байгалийн баялагаа хамгаалж буй эмэгтэйчүүд, охид удирддаг

олон нийтэд түшиглэсэн бүлгүүд нь **бүтцийн хүчирхийллийг** хэрхэн тодорхойлж, үүнээс сэргийлэх болон хариу үйлдэл үзүүлэх ямар стратегитэй байгааг сайтар ойлгохын тулд зураглал гаргаж, зөвлөлдөх арга хэмжээг хийж гүйцэтгэсэн. Тус зураглал нь **дотоод тайлан** бичихэд хүргээд зогсохгүй, доноруудад чиглэсэн **хэвлэн нийтлэл** болсон. Тайлангийн үр дүнд, газар шороо, нутаг дэвсгэр болон байгаль орчноо хамгаалах амин чухал ажлын хүрээнд бүтцийн хүчирхийлэлд өртөж буй залуу эмэгтэйчүүд, охид, транс, интерсекс болон хүйсийн аль нэг туйлд харъяалагддаггүй хүмүүсээс бүрдсэн, тэдний удирддаг байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх Форд сангийн 3 жилийн хугацаанд 1 сая ам доллар зарцуулах санхүүжилтыг GAGGA баталгаажуулж чаджээ.

4. Хамтын хүчээ нэгтгэж, оролцоог хангасан байдлаар ажиллав

Байгуулагдсанаасаа хойш GAGGA нь асуудлын огтлолцлыг гярхай харж, хөдөлгөөн бэхжүүлэх аргачлалаар ажиллаж ирсэн ба ингэснээр охид, эмэгтэйчүүд, транс, интерсекс болон хүйсийн аль нэг туйлд харъяалагддаггүй хүмүүс, тэр дундаа түүхэн явцад ялгаварлан гадуурхагдаж ирсэн хүн амын бүлгүүдээр удирдуулсан, олон нийтэд түшиглэсэн байгууллагуудын хувьд тэд уур амьсгалын хямралын шийдлээ бэхжүүлэхэд нөөц, чадавхи, мэдлэгтэй, өөр хоорондоо холбоотой байхыг бататгаж ажилладаг. GAGGA нь эдгээр байгууллагууд өөрт нөлөөлөхүйц шийдвэр гаргах гол үйл явц, олон нийт болон хүрээлэн буй орчиндоо идэвхтэй оролцож, дуу хоолойгоо өргөдөг байхыг хангахыг зорьдог. Энэ зорилтын хүрээнд 2021 оны бидний хүчин чармайлт нь дараах үйл ажиллагаанаас бүрдэв:

- Орон нутгийн, үндэсний ба олон улсын түвшинд илтгэл хурал, арга хэмжээ, уулзалт болон шийдвэр гаргах гол орон зайд түншлэгч ОНТБ-ын төлөөлөгчдыг оролцуулахаар шууд урьдаг. Олон улсын түвшинд үр дүнтэй оролцоог хангахын тулд түнш сангуудын дэмжлэгтэйгээр бид түнш байгууллагуудыг найдвартай интернет холбоо, орчуулгын дэмжлэг, бэлтгэл ажил зэрэг шаардлагатай ур чадвар, нөөцөөр хангасан.
- Хэвлэн нийтлэх материал, холбогдох баримт бичиг болон хуралдааны үеэрх синхрон орчуулгыг наад зах нь Англи, Испани, Франц, Португаль хэл рүү орчуулж хөрвүүлсэн. Боломжтой үедээ бид Бахаса Индонез, Хинди, Тагалог, Непал, Гүрж, Свахили болон Монгол хэлний орчуулгуудыг нэмсэн.
- Хамтын орон зай нь түншлэгч байгууллагуудад өөр өөр цагийн бүсэд байгаа ч хамтран ажиллах таатай нөхцөл бүрдүүлэхийг зорьсон.
- Ялангуяа охид, эмэгтэйчүүд, транс, хүйсийн аль нэг туйлд харъяалагддаггүй болон интерсекс хүмүүсийн байгаль орчин, уур амьсгалын үйл ажиллагаатай холбоотой дуу хоолой, шаардлага, саналуудыг анхааралдаа авахын ач холбогдлыг харуулсан **Англи, Испани, Франц хэлнээ дүрс бичлэгээр** дамжуулан GAGGA-гийн оролцоонд суурилсан, оролцоог хангасан, феминист зарчмуудыг сурталчилж, тэднийг хувьсган өөрчлөх чадвар бүхий чухал ажлаа удирдан чиглүүлэхэд нь дэмжиж ажилласан.

GAGGA шинэ хөтөлбөр эхлүүлж, түншүүдийн хүрээгээ тэлсэн учраас бид тус хөтөлбөрийн шинээр урган гарах хэрэгцээ шаардлагад хариулах чадамж, ажлын хэв маягаа бэхжүүлэх зорилгоор байгууллагын бүтцээ дахин сайжруулсан. Энэ үйл явцын үр дүнд бид нөлөөллийн ажлын уян хатан байдлыг хангахын төлөө зохицуулах нэгжээ бэхжүүлж, бүсийн хэмжээний зохицуулалтыг сайжруулж, улмаар нөлөөллийн ажлын түр ажлын хэсгийн бүтцээ хөгжүүллээ.

Түр ажлын хэсгийн хувьд Талуудын 26-р бага хурал нь бидэнд үзэл санаагаа дадал практикт нэвтрүүлэх том боломж өгсөн. Both ENDS, Төв Америкийн Эмэгтэйчүүдийн сан, Мама Кэш, Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сан, 350.org болон Байгаль орчин, хөгжлийн төлөөх эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөллүүдээс бүрдэх түр ажлын хэсэг нь амжилттайгаар:

- [‘Шударга ёсыг уур амьсгалын үйл ажиллагааны гол цөмд оруулах нь’](#) цуврал блогийг эхлүүлсэн нь Талуудын 26-р бага хурлын үеэр 2 долоо хоног үргэлжилсэн;
- [Жендэрийн хувьд шударга уур амьсгалын санхүүжилт сэдвээр Талуудын 26-р бага хурлын үеэр салбар арга хэмжээг](#) зохион байгуулсан;
- [Жендэрийн хувьд шударга уур амьсгалын санхүүжилтын уриа](#) гаргасан ба үүнийгээ хамтарч ажилладаг засгийн газруудын сүлжээтэй хуваалцсан.

Бид хамт олныхоо давуу талыг ашиглаж, нөлөөллийн ажлаа шат ахиулахад хүчтэй суурь бий болгож чадсан учраас энэ нь хамтын ажиллагааны далайцтай хүчин чармайлт болж чадсан.

5. Нидерланд улсын Гадаад хэргийн яамтай хамтран ажиллав

GAGGA нь Нидерланд улсын Гадаад хэргийн яамны (ГХЯ) стратегийн түнш юм. 2021 онд тус Яамтай хамтарч ажилласны дүнд гүйцэтгэсэн дараах үйл ажиллагааг онцолж байна:

- Яамны хамтран ивээн тэтгэж, гол илтгэгчдийн нэгээр оролцсон [‘Тогтвортой шийдэл – Уур амьсгалын үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг төвлөрүүлэх нь’](#) цуврал.
- УАНС-гийн Удирдах зөвлөл болон Америк Хоорондын Хөгжлийн Банкны Удирдах зөвлөл дэх Нидерландын төлөөллүүдтэй шууд санал солилцож, ярилцах орон зайг түншүүдэд зориулж бий болгосноор түүхэн явцад гадуурхагддаг байсан олон нийтийн хязгаарлагдмал оролцоо, хүний эрхийн зөрчил болон ил тод бус байдалтай холбоотой эн тэргүүний асуудлуудыг дэвшүүлсэн.
- GAGGA-гийн түншүүдийн тодорхой кейс, агуулгын тухай ойлголтыг дээшлүүлэхийн тулд Нидерландын элчин сайдын яамдтай хамтран ажилласан. Жишээ нь, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад суугаа Нидерландын элчин сайдтай хамтран ажилласнаар бид GAGGA-гийн түншүүдээс Инга 3 усан цахилгаан станцын төслийн талаар шууд сонсох боломж бүхий уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын дараа ч тус Элчин сайдын яам болон тухайн бүлгүүд Инга 3 станцын эсрэг хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна.
- Талуудын 26-р бага хурлыг угтан гол зөвлөмж бүхий [Салшгүй холбоо: жендэрийн эрх тэгш байдал, уур амьсгал ба биологийн олон янз байдлыг](#) нийтлэх зэргээр Both ENDS, Мама Кэшийн дэмжлэгтэйгээр жендэр, уур амьсгал болон биологийн олон янз байдлын асуудлаар Нидерландын засгийн газар, парламенттай хамтран ажилласан.

Дүгнэлт

Зарим хүнд нөхцөл байдлыг эс тооцвол, GAGGA-гийн ‘Эмэгтэйчүүд уур амьсгалын үйл ажиллагааг манлайлах нь’ хөтөлбөрийн эхний жил чухал үр дүнд хүрлээ. GAGGA-гийн хөтөлбөрт шинээр хамрагдсан Бразил, Мексик, Өмнөд Африк зэрэг улсын хувьсган өөрчлөх чадвартай жендэрийн хувьд шударга уур амьсгалын үйл ажиллагааг манлайлж буй эмэгтэй удирдагчидтай ОНТБ-уудын олон бүлгүүдэд бид хүрч ажиллаж, тэднийг дэмжиж чадлаа. Бид уур амьсгалын шударга ёсны талаар хамтдаа суралцаж, нөлөөллийн ажил хийснээр түншлэгч байгууллагуудтай харилцаагаа бэхжүүлэхийн зэрэгцээ, засгийн газрууд, хөрөнгө оруулагчид болон доноруудад чиглэсэн үр дүнтэй нөлөөллийн ажлуудыг дэмжиж, манлайлан ажиллав. Бид 2022 онд энэ эрч хүчээрээ ажиллаж, жендэрийн, байгаль орчны болон уур амьсгалын шударга ёсны төлөө зайлшгүй шаардлагатай хувьсган өөрчлөх чадвартай тогтолцооны өөрчлөлтөд хамтын хүчээр улам ойртоно гэдэгт итгэлтэй байна.



Гэрэл зураг: Tania Manchanda



Дэлгэрэнгүй мэдээлэл: www.gaggaalliance.org | Зургийг эвлүүлсэн: @Naandeyeah |

Хэвлэлийн дизайн: [Christina Pfeifer](#)